

МӨНГӨНИЙ СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТООЦООЛОЛ

Тооцох арга, мэдээллийн эх үүсвэр

Монголбанкнаас мөнгөний статистик үзүүлэлтүүдийг ОУВС-гаас гаргасан “Мөнгө, санхүүгийн статистикийн гарын авлага”¹-ын дагуу гаргадаг. Монголбанкнаас “Статистикийн сарын мэдээлэл”-ийг Монголбанкны веб хуудсанд урьдчилан гаргасан хуваарийн дагуу сар бүр дараах үзүүлэлтүүдийг багтаан гаргадаг болно. Үүнд:

- Мөнгөний үзүүлэлт
- Мөнгөний тойм
- Зээлийн үзүүлэлт
- Хүүний мэдээ

А. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

“Мөнгө, санхүүгийн статистикийн гарын авлага”-д мөнгөний үзүүлэлтийн тодорхойлолт байдаггүй бөгөөд энэ нь улс орон бүрийн санхүүгийн зах зээл, санхүүгийн хэрэгсэл өөр өөр байдагтай холбоотой юм. Гэсэн хэдий ч тухайн санхүүгийн хэрэгслийг мөнгөний үүргийг² биелүүлж байгаа байдлаар нь тодорхойлж, нийт мөнгөний үзүүлэлтэд оруулж тооцдог. Манай улсын хувьд мөнгөний үзүүлэлтүүдийг дараах байдлаар тооцоолж байна.

Тодорхойлолт

Одоогийн байдлаар Монгол улсын хувьд мөнгөний нийлүүлэлт-М2³ нь (1) Төв банкнаас гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгө, (2) төгрөгийн харилцах, (3) валютын харилцах, (4) цэвэршүүлсэн алтны харилцах, (5) төгрөг болон валютын хадгаламж, (6) хадгаламжийн сертификатаас бүрдэж байна. Эдгээр нь дотроо хөрвөх чадвар, гүйлгээний зардал зэрэг үзүүлэлтээрээ бага мөнгө болон бараг мөнгө гэж ангилагддаг. Хөрвөх чадвар хамгийн сайтай бэлэн мөнгө, төгрөгийн харилцах данс дахь мөнгө бага мөнгөнд, бусад нь бараг мөнгөнд тус тус орно.

Бага мөнгө

- **(1) Төв банкнаас гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгө:** Харилцах хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө татдаг санхүүгийн байгууллага (цаашид

¹ Monetary and Financial Statistics Manual, 2000

² Мөнгөний үндсэн 3 үүрэг байдаг.

- Солилцооны: Бараа, үйлчилгээ, санхүүгийн хэрэгслийг мөнгөөр худалдан авах.
- Хадгалах
- Хэмжих нэгж

³ Нийт мөнгийг зөвхөн банкуудын үзүүлэлтүүдээр 2010 оны 2 дугаар сар хүртэл тооцож байв. Харин 2010 оны 2 дугаар сараас харилцах, хадгаламж хэлбэрээр хөрөнгө татдаг байгууллага (Хадгаламж, зээлийн хоршоо)-уудын үзүүлэлтүүдийг оруулах болов.

хадгаламжийн байгууллага⁴ гэх) -уудын эзэмшиж буй цаасан болон зоосон мөнгө мөнгөний нийлүүлэлтэд орохгүй. Өөрөөр хэлбэл Төв банкнаас гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгөнөөс хадгаламжийн байгууллагуудын эзэмшиж буй цаасан болон зоосон мөнгийг хасч тооцно.

○ **(2) Төгрөгийн харилцах дахь мөнгө:** Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага (улсын болон хувийн байгууллага, бусад байгууллага⁵, бусад санхүүгийн байгууллага⁶)-ын төгрөгийн харилцах дансны үлдэгдэл орно. Харин хадгаламжийн байгууллага, гадаадын банк, санхүүгийн байгууллага, эдийн засгийн харьяат бус (оршин суугч бус), Засгийн газар⁷ (төвлөрсөн болон орон нутгийн төсөв)-ын төгрөгийн харилцах дансны үлдэгдэл мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд орохгүй.

Бараг мөнгө

○ **(3) Валютын харилцах:** Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага (улсын болон хувийн байгууллага, иргэд, бусад байгууллага⁴, бусад санхүүгийн байгууллага⁵)-ын валютын харилцах дансны үлдэгдэл мөнгөний нийлүүлэлтэд орно. Харин хадгаламжийн байгууллага, гадаадын банк, санхүүгийн байгууллага, оршин суугч бус, Засгийн газар (төвлөрсөн болон орон нутгийн төсөв)-ын валютын харилцах данс дахь мөнгө бараг мөнгөнд орохгүй.

○ **(4) Цэвэршүүлсэн алтны харилцах** мөнгөний нийлүүлэлтэд орно, харин бусад үнэт металлын харилцах дансны үлдэгдэл орохгүй.

○ **(5) Төгрөг болон валютын хадгаламж:** Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага (улсын болон хувийн байгууллага, иргэд, бусад байгууллага⁴, бусад санхүүгийн байгууллага⁵)-ын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдэл мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд орно. Хадгаламжийн байгууллага, гадаадын банк, санхүүгийн байгууллага, оршин суугч бус, Засгийн газар (төвлөрсөн болон орон нутгийн төсөв)-ын төгрөг, валютын хадгаламжийн дансны үлдэгдэл бараг мөнгөнд орохгүй.

○ **(6) Хадгаламжийн сертификат:** Хадгаламжийн байгууллагаас гаргасан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшиж буй хадгаламжийн сертификатыг мөнгөний нийлүүлэлтэд оруулна, харин бусад байгууллага (бусад хадгаламжийн байгууллага, Засгийн газар)-ын эзэмшиж буй хадгаламжийн сертификатыг оруулахгүй.

○ Тусгай зориулалттай болон хязгаарлагдмал хадгаламжийн дансдын үлдэгдэл мөнгөний нийлүүлэлтэд орохгүй. Эдгээр данснаас гүйлгээ хийхэд журам, бусад гэрээний үндсэн дээр албан ёсоор хязгаарлалт хийгддэг. Жишээлбэл, импортын

⁴ Банк, хадгаламж, зээлийн хоршоо

⁵ Сан, холбоо, үйлдвэрчний эвлэл зэрэг төрийн бус, олон нийтийн байгууллага хамрагдана.

⁶ Хадгаламжийн байгууллагаас бусад ББСБ болон бусад санхүүгийн байгууллага

⁷ Засгийн газрын санхүүгийн хязгаарлалт, зардлын шийдвэр гаргалт зэрэг Засгийн газрын онцгой чанаруудаас болж Засгийн газрын хадгаламж эзэмшигч нь макро эдийн засгийн нөлөөлөл (эдийн засгийн үйл ажилагааны чиглэл, зээлийн хүү, ханш зэрэг өөрчлөлтүүд)-д хариу үйлдэл үзүүлдэггүй учраас Засгийн газрын харилцах, хадгаламж нь мөнгөний нийлүүлэлтэд ордоггүй.

данс, эскроу данс, хаагдсан эсвэл дахин зохион байгуулагдсан санхүүгийн байгууллагуудын харилцах, хадгаламж зэрэг дансдууд орно.

Эх үүсвэр: Банкууд тайлан тэнцлээ сар бүр Монголбанкинд дараа сарын 7-ны дотор батлагдсан дансдаар нэгэн загвараар ирүүлдэг. Төв банк болон банкуудын тайлан тэнцэл дээр үндэслэн мөнгөний үзүүлэлтүүдийг сар бүр гаргадаг. Хадгаламж, зээлийн хоршоодын тайлан тэнцлийг Санхүүгийн Зохицуулах хороо улирал тутам авч нэгтгэдэг. Тус тайлангийн үзүүлэлтийг тухайн хугацааны мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд оруулах ба бусад хугацааны мөнгөний нийлүүлэлтийг тооцохдоо өмнөх улирлын үзүүлэлтийг ашиглана.

Мэдээлэл бэлтгэх хуваарь: Мөнгөний статистик үзүүлэлт болон бусад мэдээлэл гаргах хуваарийг улирал бүр урьдчилан бэлтгэж, хуваарийн дагуу Монголбанкны цахим (www.mongolbank.mn) хуудсанд байршуулдаг.

Мэдээлэлд өөрчлөлт оруулах: Мөнгөний статистик мэдээлэлд дараах тохиолдолд өөрчлөлт оруулна.

- Эх сурвалжаас алдаатай мэдээлэл ирүүлсэн, тус мэдээг засч залруулсан
- Олон улсын аргачлалыг хэрэгжүүлэх явцыг сайжруулах зорилгоор санхүүгийн хэрэгслийн ангиллыг өөрчилсөн
- Мэдээллийн хамрах хүрээг өргөтгөсөн
- Эх сурвалж өөрчлөгдсөн

Дээрх шалтгааны улмаас өөрчлөлт оруулсан тохиолдолд мэдээллийнхээ доор тодорхой тэмдэглэгээ хийх буюу урьдчилан мэдээлнэ.

Мөнгөний үржүүлэгч-ийг нийт мөнгө, нөөц мөнгөний харьцаагаар тооцдог бөгөөд нөөц мөнгөний нэгж өсөлт нь хэдий хэмжээний нийт мөнгөний өсөлт бий болгох боломжтойг харуулна.

Б. МӨНГӨНИЙ ТОЙМ: ОУВС-аас гаргасан Мөнгө санхүүгийн статистикийн гарын авлага¹-ын дагуу мөнгөний тоймд Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын тайлангийн үзүүлэлт тусгагддаг.

1. Нэгдсэн тойм: Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын үзүүлэлтүүдийн нэгтгэл.

Актив:

1. Гадаад цэвэр актив

Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын гадаад активын нийлбэр дүнгээс тэдгээрийн нийт гадаад пассивын нийлбэр дүнг хасч тооцно.

2. Дотоод цэвэр актив

Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод активын нийлбэр дүнгээс тэдгээрийн нийт дотоод пассивын нийлбэр дүнг хасч тооцно.

Дотоод цэвэр зээл

Засгийн газраас авах цэвэр авлага, бусад санхүүгийн байгууллага, улсын салбар, хувийн хэвшил, иргэд, бусад байгууллагаас авах авлагаас бүрдэнэ. Тодруулбал:

2.1. Засгийн газраас авах цэвэр авлага

Төв банк болон хадгаламжийн байгууллагын Засгийн газраас авах авлагын нийлбэр дүнгээс тус байгууллагад байршуулсан Засгийн газрын хадгаламжийн нийлбэр дүнг хасч тооцно. Мөн нийт дүнг төвлөрсөн болон орон нутгийн төсвөөр задалж харуулна.

2.2. Бусад санхүүгийн байгууллагаас авах авлага

Хадгаламжийн байгууллагаас бусад санхүүгийн байгууллагад олгосон зээлийг тооцно.

2.3. Улсын салбараас авах авлага

Хадгаламжийн байгууллагаас улсын байгууллагад олгосон зээлийг тооцно.

2.4. Хувийн хэвслээс авах авлага

Хадгаламжийн байгууллагаас хувийн байгууллагад олгосон зээлийг тооцно.

2.5. Иргэдээс авах авлага

Хадгаламжийн байгууллагаас иргэдэд олгосон зээлийг тооцно.

2.6. Бусад байгууллагаас авах авлага

Хадгаламжийн байгууллагаас бусад байгууллага (сан, холбоо, үйлдвэрчний эвлэл зэрэг төрийн бус, олон нийтийн байгууллага)-д олгосон зээлийг тооцно.

Сарын статистик мэдээлэлд “Ангилалдаагүй зээл” гэсэн үзүүлэлт байгаа нь банкууд 2004 оны 1 дүгээр сараас өмнө хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн үлдэгдлийг салбараар ангилдаггүй байсан тул тус ангилалд хамруулсан.

Пассив:

1. “Мөнгө” буюу бага мөнгө⁸ нь бэлэн мөнгө, төгрөгийн харилцах дансны нийлбэр дүнгээс бүрдэнэ.
2. “Бараг мөнгө”⁷ нь валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, төгрөг болон валютын хадгаламж, хадгаламжийн сертификатаас бүрдэнэ.

3. Бусад цэвэр зүйл

Энэ бүлэгт Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дээрх актив, пассивын бүлэгт багтаагүй бусад зүйлийг цэвэрлэж харуулдаг. Өөрөөр хэлбэл дээр дурдсан активын зүйлээс бусад активын дүн болон дээр дурдсан пассиваас бусад пассивын дүнгийн зөрүү болно. Харин Засгийн газрын шугамаар хэрэгжиж буй хөтөлбөрийн гадаад эх үүсвэрээс Монголбанкаар дамжуулан олгогдсон зээлийн эх үүсвэрийн дүнг тусад нь харуулж байгаа болно.

1.1. Төв банкны мөнгөний тойм

Актив:

1. Гадаад актив

Энэ бүлэгт Төв банкны гадаад активуудыг харуулна. Тодруулбал, касс дахь гадаад валют, гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж, гадаадын Засгийн газрын үнэт цаас, мөнгөжсөн алт, зээлжих тусгай эрх зэрэг олон улсын хэмжээнд гадаад валютын нөөцөд тооцогдох актив болон тухайн санхүүгийн хэрэгсэлд хуримтлуулж тооцсон хүүний авлага орно.

2. Засгийн газраас авах авлага

Засгийн газраас авах авлагад Төв банкны эзэмшиж буй Засгийн газрын үнэт цаас, Төв банкнаас Засгийн газарт олгосон зээл зэрэг Засгийн газраас авах авлагыг хамааруулна.

3. Банкуудаас авах авлага

Төв банкнаас банкуудад олгосон бүх төрлийн зээл, санхүүжилт орно.

Пассив:

1. Нөөц мөнгө⁹

Энэ бүлэгт банкнаас гадуурх мөнгө, банкуудын касс, банкуудын Төв банк дахь төгрөг, валютын харилцах, хадгаламж орно.

⁸ Мөнгөний нийлүүлэлтийн тодорхойлолтыг үз.

⁹ Нөөц мөнгө нь нийт мөнгө болон зээлийн өсөлтийг хангах Төв банкны пассиваас бүрддэг.

2. Төв банкны үнэт цаас

Төв банкнаас гаргасан үнэт цаасны цэвэр дүнг харуулдаг бөгөөд Төв банкнаас нийт гаргасан үнэт цаасны дүнгээс борлогдоогүй үлдэгдэл, хямдруулалтыг хасч тооцно. Мөн ТБҮЦ-д хуримтлуулж тооцсон хүүний өглөгийн дүн багтана.

3. Гадаад пассив

Төв банкны гадаад пассивын үзүүлэлтүүдийг харуулдаг. Тодруулбал, Төв банкны гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээл, Төв банк дахь гадаадын банк, санхүүгийн байгууллагуудын харилцах, хадгаламж зэрэг орно.

4. Засгийн газрын хадгаламж

Энэ бүлэгт Төв банк дахь Төрийн сангийн нэгдсэн данс, Монгол улсыг хөгжүүлэх сан, нөөцийн сан зэрэг Засгийн газрын дансдын үлдэгдлийг харуулна.

5. Хөтөлбөрийн зээлийн эх үүсвэр

Засгийн газрын шугамаар хэрэгжүүлж буй хөтөлбөрийн дагуу гадаад эх үүсвэрээс олгосон зээлийн эх үүсвэрийн дүнг тусгаж байна.

6. Өөрийн хөрөнгийн сангууд

Төв банкны дүрмийн сан болон бусад сангууд /нөөцийн сан, дахин үнэлгээний сан гэх мэт/, ашиг, алдагдал зэрэг өөрийн хөрөнгийн дансдуудыг хамруулна.

7. Бусад цэвэр зүйл

Энэ бүлэгт дээрх актив, пассивын бүлэгт багтаагүй бусад зүйлийг цэвэрлэж харуулдаг. Өөрөөр хэлбэл дээр дурдсан активын зүйлээс бусад активын дүн болон дээр дурдсан пассиваас бусад пассивын дүнгийн зөрүү болно.

1.2. Хадгаламжийн байгууллагын мөнгөний тойм:

Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх арилжааны банкууд, Хадгаламж зээлийн хоршоод¹⁰-ын үзүүлэлтүүдийг хамааруулна.

Активын үзүүлэлтүүд

1. Банкны нөөц

Банкуудын касс дахь бэлэн мөнгө, чек болон Төв банк дахь төгрөг валютын харилцах, хадгаламжийн дансаас бүрдэнэ.

2. Төв банкны үнэт цаас

Банкуудын эзэмшиж буй Төв банкны үнэт цаасны цэвэр дүнг харуулж байгаа бөгөөд уг дүнд үнэт цаасны хямдруулалт болон хуримтлуулж тооцсон хүүний авлагын дүн тусгагдаж байгаа болно.

3. Гадаад актив

¹⁰ Одоогийн байдлаар зөвхөн банкуудын үзүүлэлтүүдийг тусгаж байгаа болно. Цаашид Хадгаламж, зээлийн хоршуудын мэдээллийг оруулахаар төлөвлөж байна.

Банкуудын гадаад активын үзүүлэлтийг харуулна. Өөрөөр хэлбэл, касс дахь гадаад валют, гадаадын банк, санхүүгийн байгууллагад олгосон зээл, тэдгээрт байршуулсан харилцах, хадгаламж, гадаадын үнэт цаас, эдийн засгийн харъяат бус (оршин суугч бус)-д олгосон зээл зэрэг болно.

4. Засгийн газраас авах авлага

Банкуудын эзэмшиж буй Засгийн газрын үнэт цаас, урьдчилан төлсөн татвар зэрэг Засгийн газраас авах авлага орно.

5. Бусад санхүүгийн байгууллагаас авах авлага

Банкуудаас ББСБ болон бусад санхүүгийн байгууллагад олгосон төгрөг болон валютын зээлийн үлдэгдэл орно. Тухайн зээлд хуримтлуулж тооцсон хүүний авлага тусгагдаагүй болно.

6. Улсын салбараас авах авлага

Банкуудаас улсын байгууллагад олгосон төгрөг болон валютын зээлийн үлдэгдлийг харуулна. Тухайн зээлд хуримтлуулж тооцсон хүүний авлага тусгагдаагүй болно.

7. Хувийн хэвшлээс авах авлага

Банкуудаас хувийн хэвшилд олгосон төгрөг болон валютын зээлийн өрийн үлдэгдэл болно. Тухайн зээлд хуримтлуулж тооцсон хүүний авлага тусгагдаагүй болно.

8. Иргэдээс авах авлага

Банкуудаас иргэдэд олгосон төгрөг болон валютын зээлийн үлдэгдлийг харуулна. Тухайн зээлд хуримтлуулж тооцсон хүүний авлага тусгагдаагүй болно.

9. Бусад байгууллагаас авах авлага

Дээрхээс бусад төрлийн санхүүгийн бус байгууллагад олгосон зээлийн үлдэгдлийг тусгана. Тухайн зээлд хуримтлуулж тооцсон хүүний авлага тусгагдаагүй болно.

Ангилалдаагүй зээл

Банкууд 2004 оны 1 дүгээр сараас өмнө хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн үлдэгдлийг салбараар ангилдаггүй байсан тул эдгээр зээлийг тусад нь харуулсан. Тухайн зээлд хуримтлуулж тооцсон хүүний авлага тусгагдаагүй болно.

Пассивын үзүүлэлтүүд

1. Төгрөгийн харилцах

Банкууд дахь улсын болон хувийн байгууллага, иргэд, бусад байгууллага⁴, бусад санхүүгийн бусад байгууллага⁵-уудын төгрөгийн харилцах дансны үлдэгдлээс бүрдэнэ.

2. Хадгаламж, гадаад валютын харилцах

Банкууд дахь улсын болон хувийн байгууллага, иргэд, бусад байгууллага⁴, бусад санхүүгийн бусад байгууллага⁵-уудын валютын харилцах, төгрөг болон валютын хадгаламжийн дансны үлдэгдлээс бүрдэнэ.

3. Гадаад пассив

Банкуудын гадаад пассивын үзүүлэлтүүдийг харуулах бөгөөд гадаадын банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж, оршин суугч бус (эдийн засгийн харьяат бус)-ын харилцах, хадгаламж, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, гадаад зах зээлээс татсан бусад эх үүсвэр орно.

4. Засгийн газрын хадгаламж

Энэ бүлэгт банкуудад байршиж буй Засгийн газрын дансдуудын /төгрөг, валютын харилцах, хадгаламж, тусгай дансдууд гэх зэрэг/ үлдэгдлийг харуулах бөгөөд төвлөрсөн болон орон нутгийн төсвөөр задалсан болно.

5. Төв банкнаас авсан зээл

Банкуудын Монголбанкнаас авсан бүх төрлийн зээл, санхүүжилтийг харуулна.

6. Өөрийн хөрөнгө

Банкуудын дүрмийн сан болон бусад сангууд /нөөцийн сан, дахин үнэлгээний сан гэх мэт/, ашиг/алдагдал, 5 жилээс дээш хугацаатай хугацааны эцэст хувьцаанд хөрвөх нөхцөлтэй хоёрдогч өглөг зэрэг өөрийн хөрөнгийн дансдуудыг хамруулна.

7. Бусад цэвэр зүйл

Энэ бүлэгт дээрх актив, пассивын бүлэгт багтаагүй бусад зүйлийг цэвэрлэж харуулдаг. Өөрөөр хэлбэл дээр дурдсан активын зүйлээс бусад активын дүн болон дээр дурдсан пассиваас бусад пассивын дүнгийн зөрүү болно.

В. Зээл

Банкуудаас иргэд, байгууллагад олгосон зээлийн үлдэгдлийг зээлийн чанар буюу хугацааны үзүүлэлтээр Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү эдийн засгийн сайдын 2004 оны 459/207 тоот хамтарсан тушаалаар баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу хэвийн, хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл гэж ангилж үзүүлэхийн зэрэгцээ зээлдэгчээр улсын байгууллага, хувийн хэвшил, иргэд, бусад санхүүгийн бус байгууллага, бусад санхүүгийн байгууллага гэсэн ангиллаар харуулж байна. Мөн олгосон банк тус бүрээр, нийт дүнгээр нь үзүүлж байна. Зээлийн дүнд тэдгээрт хуримтлуулж тооцсон хүүний авлага тусгагдаагүй болно.

Г. Хүү

Банкуудын харилцах, хадгаламжийн хүүний дээд доод хязгаарыг төгрөг, валютаар нь ангилан харуулж байна. Мөн тухайн сарын эцсийн байдлаар банкуудад байршиж буй харилцах, хадгаламжийн хүүг үлдэгдлийн хэмжээгээр нь жигнэж тооцсон жигнэсэн дундаж хүүг төгрөг, валютаар нь харуулж байна.

Төв банкны үнэт цаасны хүү: Төв банкнаас тухайн сард гаргасан үнэт цаасны жигнэсэн дундаж хүү.

Засгийн газрын үнэт цаасны хүү: Засгийн газраас тухайн сард гаргасан үнэт цаасны жигнэсэн дундаж хүү.

Банк хоорондын захын хүү: Банк хоорондын зах дээр тухайн сард хийгдсэн нийт арилжааны жигнэсэн дундаж хүү. Арилжааны төрлөөр нь банк хооронд олгосон зээлийн, репо нөхцөлөөр хийгдсэн арилжааны, ТБҮЦ-ны хоёрдогч захын, овернайт зээлийн, банк хоорондын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү гэж задалж харуулдаг.

Банкуудын зээлийн хүү: Банкуудын тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж жилийн хүүг төгрөг, валютаар нь ангилан харуулдаг. Мөн банкуудын орлого зарлагын тайланд үндэслэн тооцсон бодитоор төлөгдсөн хүүг үзүүлж байна.